



## ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛ, ХҮН БА ХҮН БУСЫН АЙ БҮХИЙ БОЛСОН НЬ

Илтгэгч: Др М. Саруул-Эрдэнэ, *Ph.D*

*АНУ дахь Монгол Соёлын Төвийн тэргүүн*

0. Хэл бол үргэлж хувьсан өөрчлөгдөж байдаг тогтолцоо. Тийм учраас хэлийг хувьсал, хөдөлгөөн дунд нь судалбаас зохилтой. Анх судалж эхэлсэн цагаасаа хойш гадаад дотоодын олон монголч эрдэмтэн өөр өөрийн Монгол хэлзүйг бичжээ. Хэдийгээр Монгол бичгийн хэлний зүй, Монгол хэлний зүй хэмээн ялган тодорхойлсон боловч өнгөрсөн хоёр зуунд бичигдсэн ихэнх алдартай хэлзүйнүүд Монгол бичгийн хэлний нөлөөнөөс гарч чадаагүй, уламжлалт нэгэн шугамыг барьсан, амьд хэлэн дэх өөрчлөлт, хувьслыг тусгаж чадаагүй нийтлэг дутагдал ажиглагддаг юм. Бусад нээлттэй системийн адилаар Монгол хэл ч байнга хувирч хөгжин, зарим шинэ хэлзүйн хэлбэр, тэр ч байтугай хэлзүйн бүхэл бүтэн ай үүсч, зарим нь устан үгүй болж байна. Шинээр үүсэн бий болж буй эдгээр хандлага, хэлзүйн шинэ хэлбэр ай зэргийг Монгол хэлзүйн бүтээлүүдэд тусгах шаардлагатай юм. Энэхүү өгүүлэлдээ миний бие Орчин Цагийн Халх Монгол Хэлэнд хүн ба хүн бусыг ялган заах хэлзүйн ай нэгэнт бий болсныг батлан өгүүлэхийг зорилгоо.

### 1. Хэлзүйн ай гэж юу вэ?

Монгол хэлний хэлзүйн шинэ ай үүссэн тухай хэлэлцэхээсээ өмнө бид “ай” хэмээх ойлголтод чухам юуг авч үзэхээ нэг мөр болгох хэрэгтэй. Хэлзүйн хамгийн ерөнхий утгаар нь ай (category) гэдгийг “хэлшинжлэлийн янз бүрийн түвшин дэх хийсвэрлэл”<sup>1</sup> хэмээн тодорхойлж байна. Тиймээс үгийн санд үгийг утгаар нь ангилахаас эхлээд Үгсийг аймаглан хуваах, өгүүлбэрийн гишүүд, нэр үйлийн нөхцөлүүд зэрэг нь бүлэглэгдэн ангилагдах чанараараа бүгд энэхүү ай хэмээх ойлголтод багтах юм. Харин бид хэлний ай хэмээх ерөнхий ойлголтоос хэлзүйн ай (grammatical category) гэсэн илүү нарийн ухагдахууныг ялган, тодорхойлох нь зүйтэй юм.

Хэлзүйн айн тухай маш их судалгаа, өөр санал байгааг тэр бүр энд авч хэлэлцэх боломжгүй тул тодорхой нэг судлаачийн онолыг баримжаа болгон дагах нь ийм жижиг хүрээний ажлын зорилгод илүүтэй нийцнэ хэмээн үзэж байна. Ингээд Орчин Цагийн Монгол Хэлний зүйг тусгайлан судалсан, үгзүйч эрдэмтэн Цэдэвийн Өнөрбаянгийн онолоор хэлзүйн айг тодорхойлон авч үзье. Тэрбээр Орчин Цагийн Монгол Хэлний Үгзүй хэмээх номдоо “Нэг төрлийн ерөнхий хийсвэр харьцаа зааж байгаа хоёр ба түүнээс дээш харилцан эсрэгцсэн утгуудын нэгдэл (цогцос) - ийг хэлзүйн ай гэнэ. Өөрөөр хэлбэл, хэлзүйн хоёр ба хэд хэдэн утга нэг төрлийн харьцаа заах шинжээрээ хэлзүйн нэг айд нэгдэнэ” хэмээн тодорхойлжээ<sup>2</sup>. Жишээлбэл, монгол хэл нь ганц ба олон тооны хэлзүйн айтай, учир нь монгол хэлний ганц ба олон тооны нөхцөлүүд нь (а. –ууд, нар, –чууд, –д, –с б. тэг нөхцөл ) нэр үгийн үндсэнд орж, өөр өөр тоо илтгэх шинжээрээ эсрэгцвч нэгэн төрлийн харьцаа, өөрөөр хэлбэл тооны харьцаа заах шинжээрээ нэгдэн нэгэн айг цогцлоож байна.

Хэлзүйн ай нь хэл бүрд тоо чанараараа тохирч байх албагүй. Тухайлбал орос, франц зэрэг хэлэнд хүйсийн ай байгаа бол монгол хэлэнд тийм тусгай нөхцөл байхгүй, хүн амьтан зэргийн хүйсийг үгийн сангийн түвшинд илэрхийлэх тул монгол хэл нь хэлзүйн хүйсийн айгүй хэмээн үзэж болно. Үүнээс үзэхэд, хэдий монгол хэл хүйсийг ялган зааж чадах боловч тэр нь хэлзүйн тусгай нөхцөлөөр илрэхгүй байгаа учраас хэлзүйн ай хэмээх болзлыг хангаж чадахгүй байна.

Тусгай, өөрийн гэсэн нөхцөл байхгүй боловч зарим хэлзүйн утгыг ялгаатай илэрхийлэх чанараараа хэлзүйн ай бүрдэж болно. Жишээлбэл, орос хэлний амьтай, амьгүйн айг авч үзье. Орос хэлний амьтай, амьгүй айг ялган заах тусгай нөхцөл байна уу гэвэл үгүй. Гэвч, амьтай амьгүй нэрс ялгарах, илэрхийлэгдэх өөр орчин байна. Энэ нь юу хэмээвээс, тусгай нөхцөл үгүй ч амьтай айн нэр үгийн заахын тийн ялгалын хэлбэр нь харьяалахын тийн ялгалтай нь дүйдэг бол амьгүй айнх нь нэрлэхийн тийн ялгалтай нь адил байдаг шинжээрээ эсрэгцэж байгаа юм. Үүнээс үзэхэд хэлзүйн ай нь заавал тусгай нөхцөлтэй байх албагүй ч ямар ч байсан өөр ямар нэг байдлаар илэрхийлэгдэж байх ёстой байна.

### 2. Монгол хэлэнд Хүн ба Хүн бусыг ялгах хандлага байсан болох нь

Юуны өмнө Монгол хэлэнд нэр үгийн үндэс хүн ба хүн бусыг алин болохыг ялган заах хандлага угаас байсан болохыг энд дурдах нь зүйтэй. Монгол бичгийн хэлийг нарийвчлан судалж, хэлзүй бичсэн Н. Поппегийн бүтээлээс иш татъя: “The suffix –nar/-ner may be added to a limited number of stems ending in vowels and diphthongs with i and denoting human beings (mainly relatives and respected people) and deities. This suffix is written separately from the stem.

<sup>1</sup> David Crystal, *A Dictionary of Linguistics and Phonetics*, 3<sup>rd</sup> Edition Updated and Enlarged, Blackwell Publishers, 1991, pp 49-50

<sup>2</sup> Ц. Өнөрбаян, *Орчин Цагийн Монгол Хэлний Үгзүй*, Улаанбаатар, 2004, 14-р тал

*aq-a-nar* elder brothers  
*degüü-ner* younger brothers  
*egeči-ner* elder sisters  
*ači-nar* grandsons...<sup>3</sup>

Үүнээс үзэхэд, Монгол хэлэнд хүн ба хүн бусыг ялгах хандлага байсаар ирсэн бөгөөд энэхүү хандлага улам өргөжсөөр бүхэл бүтэн ай болон хөгжсөн байна.

### 3. Хэлэнд шинэ ай үүсэх нь

Хэлзүйн байнга хувирч өөрчлөгдөж байдаг тогтолцоо болох тухай өмнө дурдсан. Тодорхой жишээ буюу орос хэлэнд амьтай, амьгүйг ялган заах ай хэрхэн үүссэнийг авч үзье.

Орос хэлний дурдсан ай үүсэх хэлзүйн гол шалтгаан нь жинхэнэ нэрийн эр хүйсийн нэрлэх ба заахын тийн ялгалын нөхцөл адил байсан явдал юм. Өвөг Энэдхэг-Европ хэлнээ дээрх хоёр хэлбэр ялгаатай байжээ. Харин Өвөг Слав хэлний үе болж ирэхэд авиазүйн янз бүрийн хувьслын үр дүнд нэрлэх, заахын тийн ялгалын аль аль нь зарим төрлийн жинхэнэ нэрийн хувьд адил болж, балархай эгшиг *ъ, ь* (*плодь, сынъ, гостъ*) – аар төгсөх болсох ба ба хожим бүр сулран үгүй болжээ. Нэрлэх, заахын тийн ялгал ийнхүү адил хэлбэртэй болсноор үйлийн эзэн, үйлд өртөгч хоёрыг ялгахад бэрхшээлтэй болсон байна. Ялангуяа амьтай биетүүд, тухайлбал хүний хувьд үйлийн эзэн, тусагдахуун хоёрын аль аль болох бололцоотой тул улам ээдрээтэй болжээ. Иван победил Петр – Хэн хэнийг ялсан бэ? Энэ тодорхойгүй байдлаас орос хэл гарах арга замаа хэрхэн сонгов? Хуучин заахын тийн ялгалынхаа хэлбэрийн оронд харьяалахын тийн ялгалтай тохирох өөр хэлбэр хэрэглэх болсон байна. Иван победил Петра. Эхлээд ийм хэлбэрийг зөвхөн эр хүйсийн жинхэнэ нэрд хэрэглэж байсан бол яваандаа нийт амьтай юмсын хувьд ч хамаатай болсон байна. Ийнхүү Орос хэлэнд амьтай ба амьгүйн шинэ ай үүсэв<sup>4</sup>.

Эндээс үзэхэд, хэлэнд шинэ ай үүсэхэд хэлзүйн тодорхой хандлага, авиазүйн тодорхой хувьсал нөлөөлдөг байна.

### 4. Орчин Цагийн Монгол Хэлэнд Хүн ба Хүн Бусын Ай үүсэх авиазүйн орчин бүрдсэн нь

Монгол хэлэнд урт, хос эгшгээр төгссөн нэр үндэс бий болсон нь хүн ба хүн бусын ай үүсэх нөхцөл болсон байна. Өөрөөр хэлбэл авиазүйн хувьсал үгзүйн шинэ шатанд хүргэжээ. Тухайлбал (а) нэр үгийн үндэс дэх төгсгөлийн зарим *n* гийгүүлэгч балархайшин гээгдэхийн зэрэгцээ (b) урт, хос эгшиг үүсэн, маш олон нэр үндэс урт, хос эгшиг төгсгөлтэй болсноор зарим тийн ялгалын нөхцөлийг залгах тогтсон дүрэм үйлчлэхэд бэрхшээлтэй болж эхэлсэн байна.

Монгол Бичгийн Хэлний харьяалах, гарахын тийн ялгалын нөхцөлийг залгах дүрмийг авч үзье.

4.1. Харьяалахын тийн ялгалын *-yin* нөхцөлийг эгшгээр төгссөн үгэнд, *-u/-ü* нөхцөлийг *n* гийгүүлэгчээр төгссөн үгэнд, *-un/-ün* нөхцөлийг *n*-ээс бусад бүх гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгана. Жишээ нь: *er-e-yin, morin-u, ulus-un*

4.2. Гарахын тийн ялгалын *-ača/-eče* нөхцөлийг үндсийн төгсгөлийг үл харгалзан эгших зохицох ёсны дагуу залгана. Жишээ нь: *dalai- ača, ger- eče*

Энд эгшгээр төгссөн үндэс гэдэг нь богино эгшгийг хэлж байна. Гэтэл Дунд Үеийн Монгол Хэлнээс эхлэн урт эгшиг үүсч, энэхүү дүрэмд үл захирагдах үгийн үндэс олноор бий болжээ. Тиймээс Монгол хэлний тийн ялгалын нөхцөлийг залгах шинэ дүрэм боловсрох шаардлагатай болсон байна.

### 5. Орчин Цагийн Монгол Хэлний Хүн ба Хүн бусын ай

Урт, хос эгшиг үгийн эцэст үүссэнээр дээр дурдсан тийн ялгалуудын шинэ хэлбэр үүсч эхэлснийг батлах баримтууд бий. Жишээ нь Монгол бичгийн хэлэнд ярианы хэлний нөлөөгөөр урт, хос эгшгийн дараа харьяалахын тийн ялгалын *-giyin* нөхцөл залгасан жишээ тохиолддог. Жишээлбэл: *buluu-giyin*

Ийнхүү хуучин байсан *-yin, -un*, авиазүйн хувьслын үр дүнд шинээр бий болсон *-giyin* зэрэг нөхцөлүүд хэлний аяндаа цэгцрэх хуулийн дагуу, мөн Монгол хэлэнд угаас байсан хандлагыг үргэлжлүүлэн, харьяалах, гарахын тийн ялгалын өвөрмөц өөр хэлбэрийг бий болгосноор Монгол хэлэнд хүн ба хүн бусын ай үүссэн байна. Жишээгээр үзүүлье:

<sup>3</sup> Nicholas Poppe, *Grammar of Written Mongolian, 4th Unrevised Edition, Otto Harrasowitz, Wiesbaden, 1991, p 69*

<sup>4</sup> Энциклопедический словарь юного филолога (языкознание), Сост. М. В. Панов, Москва, Издательство Педагогика, 1984

Харьяалахын тийн ялгал:

Урт, хос эгшгийн дараа	
<u>Хүн бус</u>	<u>Хүн</u>
Туяаны	Туяагийн
Барааны	Нараагийн
Сүүний	дүүгийн
Ширээний	эмээгийн

Гарахын тийн ялгал:

Урт, хос эгшгийн дараа	
<u>Хүн бус</u>	<u>Хүн</u>
Туяанаас	Туяагаас
Бараанаас	Нараагаас
Сүүнээс	дүүгээс
Ширээнээс	эмээгээс

Сонирхолтой нь үйлдэхийн тийн ялгалын хувьд хүн ба хүн бусыг ялгах хэлбэрүүд үүсээгүй байна.

Үйлдэхийн тийн ялгал:

Урт, хос эгшгийн дараа	
<u>Хүн бус</u>	<u>Хүн</u>
Туяагаар	Туяагаар
Бараагаар	Нараагаар
Сүүгээр	дүүгээр
Ширээгээр	эмээгээр

#### **6. Хүний холбогдолт айд багтах бусад нэрс**

Аливаа айн цөмийг бүрдүүлэх үндсэн нэгж байхаас гадна түүнд хамаарах захын элементүүд гэж бас байдаг. Үүнчлэн, Монгол хэлний Хүний холбогдолт айд багтан харьяалахын тийн ялгалын –*гийн*, гарахын тийн ялгалын –*гаас* нөхцөл авдаг бүлэг үгс бол Монголчуудын эртнээс нааш хүншүүлэн сэтгэж ирсэн гол усны болон бусад оноосон нэрс юм. Жишээлбэл Хараа хэмээх үг хүний нүдний харах чадварыг заах үг болохын хувьд “Харааны шил” хэмээн –*ний* хэлбэрийг авч байгаа бол “Хараагийн гол” хэмээн оноосон нэрийн үүрэг гүйцэтгэхдээ –*гийн* нөхцөлөөр хэлбэржинэ. Үүнчлэн Борооны үүл гэдэг бол Бороогийн уурхай хэмээнэ.

#### **7. Жийрэглэх авиа бүхий шинэ нөхцөл үүсэх нь**

Орчин цагийн Монгол хэлзүйн сурах бичгүүдэд харьяалах, гарахын тийн ялгалыг –*ын*, –*ийн*, –*аас* гэх мэт нөхцөлтэй хэмээгээд урт хос эгшгээр төгссөн үгийн дараа ороход заримдаа *Г*, заримдаа *Н* гийгүүлэгч жийрэглэнэ хэмээн заасаар байна. Гэтэл тэр “заримдаа” хэмээх үг нь шинжлэх ухаанд тийм ч оновчтой томъёолол бус. Бидний үзэж буйгаар харьяалахын тийн ялгалын –*ны*, –*гийн*, гарахын тийн ялгалын –*аас*, –*наас*, –*гаас* гэсэн тусгай нөхцөлүүд аль хэдүйн буй болжээ. Анх жийрэглэх үүрэгтэй байсан мөнөөх *Н*, *Г* гийгүүлэгчүүд ийнхүү бие даасан нөхцөлийн салшгүй нэгэн хэсэг болсонтой яг адил хувьсал өмнө нь Монгол хэлэнд бас тохиож байсан байна. Тухайлбал Эртний Монгол хэлний олон тооны –*д* нөхцөлийг гийгүүлэгчээр төгссөн үгийн ард залгахад холбох эгшиг *и* ордог байсан нь яваандаа олон тооны –*д* нөхцөлөөс гадна бас тусгай –*ууд* хэмээх нөхцөл бий болоход хүргэсэн байна.

#### **Дүгнэлт**

Орчин Цагийн Монгол Хэлэнд нэр үндсийн хүн ба хүн бусыг ялган заах харьяалах, гарахын тийн ялгалын тусгай нөхцөлүүд нэгэнт бүрэлджээ. Хүн ба хүн бусын ай нь Монгол хэлэнд цоо шинэ зүйл бус, Эртний Монгол хэлэнд ч хүн ба хүн бусыг ялган заах хандлага (тооны нөхцөлд) байсан бөгөөд энэ нь урт эгшиг үүсэх авиазүйн хувиралтай уялдан улам бүр нарийсан хөгжсөн байна. Хүн ба хүн бусыг ялган заах хэлбэр ийнхүү олон тоо, харьяалах, гарахын тийн ялгалын хэлбэрүүд дээр ялгаатай байгаа нь хэлзүйн утга, хэлбэр, айн тухай онолын үүднээс нэгэнт тусгай ай бий болсныг баталж байна. Тиймээс хэлзүйн сурах бичиг, лавлах толь зэрэгт энэ айг оруулж байх нь зүйтэй юм.